

НҮҮДЭЛЧИН МОНГОЛЧУУДЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГЫГ МӨШГӨН ҮЗВЭЭС...

О.Уранчимэг, дэд профессор, УБТС

Abstract: Recent research of historical science has proved that people of the nation lived in the territory, created its unique traditions and customs and influenced other civilizations.

The terms “Nomadic Mongolians” and “Nomadic tribes” refer and describe mostly the nation differing from other nations.

Alexey Pavlovich Okladnikov, an academician, a Russian scientist, emphasized that the territory, which today’s nomadic Mongols live in, is an ancient homeland of human civilization while Mongolian scientist and historian B. Sumiya has determined that Mongolia is the native country of nomadic civilization so that these determinations are the main tools of the research work.

Удиртгал

Дэлхийн хүн төрөлхтний оюун сэтгэлгээний болон соёл судлалын ухааны санд Монголчуудын баялаг түүх, уламжлал, бахархах ёс заншил, дорнын өндөр соёлыг давтагдашгүй өвөрмөц өнгөөр дархлаан шингээж чадсан гайхамшигтай ард түмэн бол Монголчууд билээ.

Монголчуудын ёс заншил, зан үйлийн соёлын талаар нарийн чанд хуулиуд үйлчилж байсан тухай “Монголын нууц товчоо”, Рашид-ад-дины “Судрын чуулган”, Плано Карпини, Гильом де Рубрук, Марко Поло зэрэг XIII зууны үед Монгол нутгаар аялж байсан гадаадын элчин, жуулчдын тэмдэглэл, дурсамж, түүхэн олон эх сурвалжуудад тодорхой өгүүлсэн байдаг.

Ийнхүү “соёл” гэдэг ойлголт өөрөө, бүхэллэг шинжтэй нийгмийн үзэгдэл учраас түүнийг эртний судлал, угсаатны зүй, хүн судлал, хэл шинжлэл, урлаг судлал, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх ухаан, нийгэм түүх, философи зэрэг нийгмийн хүмүүнлэгийн олон шинжлэх ухааны судалгааны чухал хэрэглэгдэхүүн болон ашигласаар байна.

Германы философич О.Шпенглер “хүн төрөлхтний нэгдмэл соёл гэж байхгүй, байж ч болохгүй” харин соёл тус бүрд амьд биеийн адил бага, идэр, өтөл насыг наслах бөгөөд энэхүү хөгшрөлтийн шатыг “Соёл иргэншил” гэнэ. Соёл иргэншил хүчирхэгжин мандаж, доройтон мөхөж, нэг нь нөгөөгөө халж сольж, нэгийнхээ эрхшээлд нөгөө нь орж, харилцан байраа солилцох гэх мэтээр хөгжиж ирсэн түүхтэй байна.

Түүхийн шинжлэх ухааны өнөөгийн судалгаагаар Монгол нутагт хүн суурьшин амьдарч, өөрийн өвөрмөц соёлоо цогцлон бүтээж,

нийт хүн төрөлхтний соёл иргэншилд зохих хувь нэмрээ оруулсаар ирснийг судлан тогтоосон байдаг (Очир, 2005, х.247).

Монголын нүүдэлчин ард түмэн дэлхийн хаана ч байхгүй, ариун нандин эрхэм соёлыг өөрийнхөө түүхэнд бүтээж, өвөг дээдэс маань түүнийгээ зэврээж гандаалгүй бидний үеийнхэнд хүргэж чадсан агуу хүмүүс билээ.

“Нүүдэлчин Монгол”, “Нүүдэлчин аймгууд” гэсэн нэр томьёо эдүүгээ цагт Монголчууд, Монгол (Очир, 2005, х.228) орон гэсэн ойлголтыг бусад улс орноос ялгаруулах тодотгол болон хадгалагдсаар байна.

Оросын эрдэмтэн, академич А.П.Окладников ... Өнөөдрийн Монголын газар нутаг бол хүн төрөлхтний иргэншлийн эртний нэгэн голомт” гэж онцлон тэмдэглэсэн байхад Монголын түүхч эрдэмтэн Б.Сумьяа ...Монгол орон бол нүүдлийн соёл иргэншлийн уугуул голомт” хэмээн тодорхойлсон нь судалгааны үнэт хэрэглэгдэхүүн болсон юм.

Бидний эхний алхам бол Монголчууд нүүдэллэх (Тэрбиш, 2009, х.208) явцдаа бие бялдраа хэрхэн, яаж хөгжүүлж ирснийг тодруулах явдал байв.

Үндсэн хэсэг

Төв Азийн элгэнд Монгол түмэн таван төрөл малаа маллаж аж төрөхдөө малын билчээр, малчны хот, монгол гэр, мал маллах монгол арга ухаан, төрт ёс, оюуны болон эд өлгийн соёл, монгол хүний өөрийн иргэншил энэ бүхний цогцыг Монголчуудын “нүүдэл” хэмээх ойлголтод багтаан авч үзэх сонирхол төрсөн юм.

Монголчууд яагаад нүүдэллэн аж төрөв болов ? (Баттулга, х.639)

гэхлээр нутаг орон нь өргөн уудам, хүн ам нь цөөн, таруу амьдардаг, хур тундас хомс, ой мод, ус намаг бага, цаг агаарын эрс тэс уур амьсгал зэргээс шалтгаалан нүүдэллэн аж төрөх болсон байна. Нүүдэлчдийн хамгийн гайхамшигтай зүйл нь

“ хэзээ ирэх нь мэдэгдэхгүй,
хашаа явах нь тодорхойгүй,
нэхэн хөөхөд баригдадгүй”

зэрэг олон давуу талууд байдгийг түүхийн сурвалж бичгүүдэд дурджээ.

Нүүдэллэн амьдрах хэв маяг нь нэгдэн нягтрах аргын нэг бөгөөд “ Дэм дэмдээ дээс эрчиндээ” байхын сонгодог жишээ бол монголчуудын хот айл хэлбэрээр амьдрах ёс юм. Хот айл нь саахалт айлтай байж “Айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг” болж мал аж ахуйн хүнд хүчир ажил үйлийг санаа нийлэн явуулдаг байсан уламжлалтай.

Иймээс өвөг дээдсийнхээ бүтээн буй болгосон үндэсний уламжлалт соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх нь хүн төрлөхтний уламжлалт ухаан гэж ойлгон, монголчууд бие бялдрын хөгжил, хүмүүжлээ хэрхэн олж авч ирсэн юм бэ? гэдэг талаас нь асуудал дэвшүүлэн судлахын зэрэгцээ, монголчууд хөдөлмөрлөх явцдаа бие бялдрын ямар ямар чанаруудыг, ямар аргаар хэрхэн, яаж олж авч ирснийг судлах зорилго тавьсан юм.

Бие бялдрын хүмүүжлийн асуудлаа хэрхэн шийдвэрлэж ирснийг нь :

I. Ахуй амьдрал, ажил хөдөлмөр (ан ав хийх, морь малтай харьцах, жин тээх...)

II. Шүтлэг бишрэл (эрх эргүүлэх, сүм дуганд мөргөх, гороо хийх)-тэй нь холбон “дасгал хөдөлгөөн” гэсэн ойлголтод шилжүүлэн бие бялдрын хүмүүжил, соёлын хүрээнд багтаан авч үзэхийг зорьсон юм.

Эрт үеэс дэлхийн олон улс үндэстэн, хүн амынхаа бие бялдрын өсөлт, хөгжилтөд онцгой анхаарч үлэмж алдартай Немц, Франц, Шведийн гимнастикийн системүүдийг бий болгож ирсэн түүхтэй. Манай ард түмэнд ч гэсэн өөрсдийн бие бялдраа хөгжүүлж ирсэн арга ухаан, туршлага байсан нь тодорхой. Энэхүү арга ухааныг нь судлан илрүүлж монгол хүний биеийн хүч чадал, тэсвэр хатуужил, эр зориг нь чухам юунд байсан, түүнийгээ хэрхэн олж авч байсан талаар сонирхон судалсан юм.

Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг монголчууд байгаль цаг уурын аясыг даган дөрвөн улиралд нутаг сэлгэн нүүдэллэн аж төрөхдөө: нэг талаас

нь харахад амьдралынхаа төлөө тэмцэж буй биеийн хүчний хөдөлмөр, нөгөө талаас нь харахад өдөр тутмын хөдөлмөр нь алхах, гүйх, харайх, шидэх ... зэрэг хөдлөл, хөдөлгөөний үйлдлүүдээр илэрч улмаар хурд, хүч чадал, бяр тэнхээ, тэсвэр хатуужил олж авдаг байжээ гэсэн таамаглал гарган авахад хүргэсэн юм.

Судалгааны ажлын үр дүнгээр эхлээд “Монгол гимнастик” гэсэн нэр томъёог гаргаж авсан боловч, гүнзгийрүүлэн судлах явцад нүүдлийн малчдын өдөр тутмын хөдөлмөрийн үйл ажиллагаа, түүний агуулга нь “Гимнастик” хэлбэрээсээ “дасгал хөдөлгөөн” тал руугаа илүү дөхөмтэй байгаа нь харагдсан юм.

Дээрх таамаглалаа дараах зүйлүүдээр нөхцөлдүүлэн авч үзлээ.

Америкийн судлаач А.Кребер, С.Клаккон (1982) нар “Эдүүгээ соёлын тухай 300 орчим тодорхойлолт байна” тэдгээрийн ихэнх нь соёлын гол эх сурвалжаа “хүний хөдөлмөр” юм гэж бичсэн байдаг.

Монголчууд нь зэрлэг ан амьтадыг гаршуулан гэрийн тэжээмэл мал болгон байгаль цаг агаарын аясыг даган нүүдэллэн ан ав хийж, мал сүргээ үржүүлж, ашиг шимийг нь боловсруулж, гар үйлдвэрлэл явуулах зэргээр амьдралынхаа хэв маягаа зохицуулж ирсэн ард түмэн билээ. Иймээс нүүдэлчдийн хөдөлмөр, тэдгээрийн ажлын агуулга нь орон зай, цаг хугацааны туршид үргэлж сөрөн тэмцэлдэх үйл явц байсан магадлал өндөр байна.


Нүүдэлчин ард түмэн маань хөдөлмөрийн багаж зэвсгээ сайжруулж, оюун ухаанаа хөгжүүлж, аливаа зүйлийг хийж бүтээх болон сурах арга барилд байнга дадлагажин, хүч чадал, авхаалж самбаа, тэсвэр хатуужил гарган хөдөлмөрлөх явцдаа бие бялдрын хувьд боловсорч ирсэн уламжлалт ёс нь хадгалагдсаар өнөөг хүрчээ.

Малчин удамтай нүүдлийн аж ахуй эрхэлдэг ард түмэн худаг ус гаргах, ховоо татах, аргал түүх, жин тээх, унага тугал татах, эмнэг хангал сургах, нүүдэл суудал хийх, эрх эргүүлэх, сүм дуганд сунаж мөргөх ... (“Монгол ёс заншлын дунд тайлбар толь” 1991, х.259) зэрэг олон төрлийн ёс заншлуудтай байсан нь тодорхой билээ.

Дээрх хөдөлмөр ахуй, зан заншил, шашин шүтлэгтэй холбоотой үйл ажиллагааг нэгтгэн боловсруулалт хийж үзэхэд монголын малчдын өдөр тутам хийгддэг ажил хөдөлмөр нь өөрөө биеийн тамирын “дасгал хөдөлгөөн” байжээ гэж үзээд тус бүрийнх нь агуулгыг тодотгон гаргаж үзэхийг зорилоо.

Хүснэгт 1

Монголчуудын нүүдлийн соёл иргэншил дэх бие бялдрын хүмүүжил



Нүүдлийн малчдын өдөр тутам хийгддэг хөдөлмөр ахуй болон шашин шүтлэгтэй нь холбоотойгоор гарган авсан дээрх ангиллыг төрөл зүйгээр нь задлан шинжлэх үүднээс заримаас нь жишээ болгон авч үзлээ.

Нүүдэлчин ард түмний хоол ундаа болгож идэх, түлээ түлш нь “Аргал” юм Таван хошуу малын баасыг аргал гэнэ. Аргал түүх үндсэн хэрэгсэл нь “Араг”, “Савар” хоёр юм. Араг нь их, бага, дунд зэрэг хэмжээтэй.

Газраас савраар аргалыг авч ар нуруундаа үүрч яваа “араг” руу онож шидэж дүүргэнэ. Аргал түүх талбай нь малын бэлчээрийн хол ойроос шалтгаалан маш их өргөн уудам орон зай бөгөөд хамгийн багаар бодоход 3-4 цаг зарцуулна.

Аргал түүх нь уян хатан хөдөлгөөн, авхаалж самбаа, тэсвэр тэвчээр олгож байдгийн зэрэгцээ булчингийн хүчийг хөгжүүлж, үе мөчний өвчнөөс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой хөдөлмөрийн нэг мөн...

Энэ мэтчилэнгээр дээрх ангиллыг нэг бүрчлэн задлан бичих аваас монгол хүн бие бялдрын өсөлт, хөгжилтөө юунаас, яаж, хэрхэн олж авч байсан нь тодорхой харагдах болно

Монголчууд нүүдэллэн аж төрөх явцдаа “Эрийн гурван наадам” хэмээх барилдах, уралдах, харвах ур чадварыг өөртөө агуулсан нэгэн төрлийн баяр цэнгээнийг үүсгэн бий болгосон явдал нь бие бялдрынхаа ид хавийг харуулсан томоохон жишээ болно.

ДҮГНЭЛТ

- Нүүдлийн соёл иргэншлийн үеийн монголчуудын бие бялдрын хүмүүжлийн асуудлыг хөндөн тавьж буйгаараа онцлог талтай.
- 30 орчим нэр төрлийн хөдөлмөрийн үйл ажиллагааг ангилан авч үзсэний учир нь судалгаа шинжилгээний ажил сонирхдог хүмүүст судалгааны ажлын объект болгон тал талаас нь судлах боломжийг олгож байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Очир, А. (2011). Монголын түүхийн судалгаа. Улаанбаатар
- Жиованни, Дель., Пано, Карпини. (1988). Монголчуудын түүх. Улаанбаатар
- Дугар-Нимаев, Ц.А. (1971). Очерки истории культуры МНР. Улан-Үдэ
- Ганхуяг, Ш. (1998). Нүүдлийн ба суурин соёл иргэншлийн харилцан нөлөөлөийн гүн ухааны судалгаа. Дэд докторын диссертаци. Улаанбаатар
- Латимор, О. (1994). Нүүдэлчид ба хувьсгалчид. Улаанбаатар
- Сумъяа, Б. (1998). Монголын нүүдэлчдийн соёл. Улаанбаатар
- Ганбаатар, Я. (1997). Хүннү ба Монголчуудын өвөг дээдэс. Улаанбаатар.
- Түүхийн хүрээлэн. (1996). Бүгд Найрамдах Монгол Ард улсын угсааатны зүй I боть. Улаанбаатар.
- Шинжлэх Ухааны Академи, Түүхийн хүрээлэн. (2009). Монгол ёс заншил, зан үйлийн товчоон. Улаанбаатар
- Сажаа Бандид Гунгаа Жалзан. (1990). Эрднийн сан субашид. Улаанбаатар